

## Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

### Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар

#### 2023 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03	39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	Гамшгаас хамгаалах чиглэлээр сумын Засаг даргын нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлж ажилласан.сумын Засаг даргын нөөц хөрөнгө 10 сая төгрөгөөр батлагдсан ба тодотголоор 3,1 сая төгрөгийг нэмж батлуулан нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлсэн.	100%	100%	
2	2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг	Малчид, төлчдийн зөвлөгөөн"-д оролцсон нийт 184 иргэд болон "Баялагч бүтээгчдийн үзэсгэлэн худалдаа"-нд оролцсон 50 гаруй иргэд, мөн Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 27 сурагч, 11 дүгээр ангийн 25 сурагч, 10 дугаар ангийн 25 сурагчдад "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аргууд" сэдэвт сургалтыг хийсэн. Сургалтын үр дүнд иргэд болон сурагчид гэр бүлийн хүчирхийллээс болж үүсэх сөрөг үр дагаврууд, урьдчилан сэргийлэх аргууд, хэрхэн мэдээлэх талаар тодорхой ойлголттой болсон. Мөн гэр	100%	100%	

		үүргийг хэрэгжүүлнэ:)	<p>бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг QR код хэлбэрт оруулан иргэд гар утсандаа татан авч унших боломжтойгоор тараах материал бэлтгэн тараасан.Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр “Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжил хамгаалалд хамтдаа” нэгдсэн өдөрлөг зохион байгуулж “Өсвөр насны хүүхэдтэй харилцахдаа анхаарах асуудал” сургалтад нийт 108 эцэг эхчүүдийг хамруулж ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 5 кейс нээн Хамтарсан багаараа төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад гэр бүлийн хүчирхийлэл энэ онд 16.7%-иар буурсан байна. Хохирогчийг хамгаалах байрыг Цагдаагийн хэсгийн хажууд тохижуулсан.</p> <p>Хавсралт : 2 зураг</p>			
	3	18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;	сумын ИТХ-р сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээг холбогдох төсвийн хамт батлуулсан.	70%	70%	

		(18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)				
4		19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Иргэдийн хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр Иргэний танхимын мэдээллийн самбарт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хуулиудыг QR код хэлбэрт оруулан иргэд гар утсандаа татан авч унших боломжтойгоор байршуулсан. “Малчид, төлчдийн зөвлөгөөн”-д оролцсон нийт 184 иргэд болон “Баялагч бүтээгчдийн үзэсгэлэн худалдаа”-нд оролцсон 50 гаруй иргэд, мөн Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 27 сурагч, 11 дүгээр ангийн 25 сурагч, 10 дугаар ангийн 25 сурагчдад “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аргууд” сэдэвт сургалтыг хийсэн	100%	100%	
5		19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь	Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2023 оны 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Улаанбаатар олон улсын их сургуулийн доктор багш Р.Оюун-Эрдэнэ, Ө.Байгаль нарын “Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” сургалтад Хамтарсан багийн гишүүд хамрагдан хүчирхийлэл үйлдэгчтэй хэрхэн харьцах	100%	100%	

		чиг үүргийг хэрэгжүүлнэ.)	талаар мэдлэг, туршлага хуримтлуулсан. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах нь” сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 25,26-ны өдрүүдэд зохион байгуулж Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Сургуулийн нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, Хэсгийн төлөөлөгч гэсэн гишүүд сургалтад хамрагдсан. Сургалтын үр дүнд хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэг болон хамтарч ажиллах арга зүйд суралцсан. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар Цагдаагийн газартай хамтран “Харилцан туршлага солилцъё-хамтдаа хөгжье” бүсийн туршлага солилцох уулзалт зохион байгуулж Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Сургуулийн сэтгэл зүйч, Халамжийн мэргэжилтэн, Цэцэрлэгийн арга зүйч, Хэсгийн төлөөлөгч гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Жинст сумд бүсийн уулзалтад оролцсон. Үүний үр дүнд бусад сумдын сайн туршлагатай танилцаж, Хамтарсан багийн төлөвлөгөөг хэрхэн гаргах мөн хэрхэн гишүүдтэй уялдаа холбоотой ажиллах зэрэг аргуудад суралцсан.			
	6	19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн	сумын ИТХ-р сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээг	70%	70%	

		хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	холбогдох төсвийн хамт батлуулсан.			
	7	19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Санхүүжилтээс шалтгаалан энэ ажил төсөвт тусгагдаагүй. Хагас жилийн хурлаах нэмж тусгуулахаар төлөвлөсөн.  Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс	30%	30%	
	8	19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг	нийгмийн бодлогын мэргэжилтэн хохирогчтой ганцаарчлан уулзах зориулалтын өрөөтэй. Хохирогчийг	100%	100%	

		дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	хамгаалах байрыг цагдаагийн хэсгийн хажууд тохижуулсан.  Хавсралт : 2 зураг			
9		19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байхгүй. Төрийн байгууллагуудтай хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулсан.	100%	100%	
10		19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж	урамшуулсан зүйл байхгүй  Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас	0%	0%	

			байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)			
3	11	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар баталж, төлөвлөгөө гаргаж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай хэрэгжиж 9,652,950 төгрөгийг ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад зарцуулсан. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах бүрдүүлэх үүднээс шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Албан хаагчдыг холбогдох мэргэжлийн сургалтуудад бүрэн хамруулсан. Хөтөлбөр баталж хэрэгжүүлснээр байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгаа сайжирч, төрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, түргэн шуурхай явуулж байна.	100%	100%
4	12	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн	7.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь улсын түвшинд үндэсний хөгжлийн	хамааралгүй заалт	100%	100%

		найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас бүрдэнэ.				
УИХ-ын тогтоол							
5	13	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг	Зорилтот бүлгүүдэд чиглэсэн тусламж үйлчилгээнд 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ахмад настны тэтгэврийн үйлчилгээнд 1 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн үйлчилгээнд 33 иргэн, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 17 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмжид 11 хүүхэд, ахмад настны хөнгөлөлт тусламжид 77 иргэн, насны хишигт 161 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 3 иргэн, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 74 иргэн тус тус хамрагдсан	100%	100%	



			дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	байна.Ерөнхий боловсролын сургууль, Дотуур байр, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн байгууллагууд дээр камерын үйл ажиллагаанд шалгалт хийж, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавин ажиллалаа. Камерууд бүгд хэвийн ажиллагаатай, хүүхдийн эрх зөрчигдсөн асуудал гараагүй байна.			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
6	14	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах,	2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад	Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх үзлэгт 2023 онд 376 хүн хамрагдсан. Цэргийн насны 120 хүнийг үзлэгт хамруулахад бэлгийн дамжих өвчин илрээгүй. Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс сэргийлэх талаарх сургалт сурталчилгааг 120 хүнд хийж, брошур болон мэдээлэл бүхий гарын авлагыг 132	100%	100%	

		урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	хяналт тавих.	хүнд тараасан.			
7	15	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах,	Малчид, төлчдийн зөвлөгөөн”-д оролцсон нийт 184 иргэд болон “Баялагч бүтээгчдийн үзэсгэлэн худалдаа”-нд оролцсон 50 гаруй иргэд, мөн Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 27 сурагч, 11 дүгээр ангийн 25 сурагч, 10 дугаар ангийн 25 сурагчдад “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аргууд” сэдэвт сургалтыг хийсэн. Сургалтын үр дүнд иргэд болон сурагчид гэр бүлийн хүчирхийллээс болж үүсэх сөрөг үр дагаврууд, урьдчилан сэргийлэх аргууд, хэрхэн мэдээлэх талаар тодорхой ойлголттой болсон. Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг QR код хэлбэрт оруулан иргэд гар утсандаа татан авч унших боломжтойгоор тараах материал бэлтгэн тараасан.Сумын Засаг даргын захирамжаар “Хүүхдээ сонсох өдөр”-ийг сар бүрийн эхний долоо хоногийн Пүрэв гаригт тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэсэн. Уг захирамжийн хүрээнд Хүүхдээ сонсох өдрийн арга хэмжээг Ерөнхий боловсролын 4-12 дугаар ангийн сурагчдын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулж Хүүхдийн эрхий тухай	100%	100%	

			хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар сургалт зохион байгуулж, сургуулийн орчин дахь ялгаварлан гадуурхалт, үе тэнгийнхний дарамт шахалт, олон нийтийн арга хэмжээн дэх хүүхэд хамгаалал сэдвийн хүрээнд сурагчдын үзэл бодлыг сонсон хэлэлцүүлэг өрнүүлсэн. Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар хэлэлцүүлгийг дүгнэн хүүхдүүдийн санал хүсэлтийг дэмжин ажиллахаа илэрхийлсэн. Худалдаа үйлчилгээ эрхлэгч нарын харилцаа хандлага муу байдаг гэсэн санал гарсантай холбогдуулан худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт Засаг даргын албан бичиг хүргүүлж ажилласан. Ерөнхий боловсролын сургууль, Дотуур байр, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн байгууллагууд дээр камерын үйл ажиллагаанд шалгалт хийж, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавин ажиллалаа. Камерууд бүгд хэвийн ажиллагаатай, хүүхдийн эрх зөрчигдсөн асуудал гараагүй байна.			
8	16	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04	1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг	умын хэмжээнд 81022 малыг халдварт өвчнөөс урьчилан сэргийлэх вакцинд хамруулахаар Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч А.Элдэв-Очир мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж оруулсан. Баянлиг түмэн тэмээ мал эмнэлэг 6 төрлийн вакцинд 17686 толгой мал хамруулахаас 17367 толгой мал хамруулж гүйцэтгэл 98.20%, Баянлиг буянт сүрэг мал	100%	100%	

		БОХХААБХ	бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох;	эмнэлэг 6 төрлийн вакцинд 27173 толгой мал хамруулахаас 26130 толгой мал хамруулж гүйцэтгэл 96.16%, Хар ботго мал эмнэлэг 8 төрлийн вакцинд 36163 толгой мал хамруулахаас 35932 толгой мал хамруулж гүйцэтгэл 99.36%-тай байна. Сумын хэмжээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 167757 толгой мал хамруулахаас 163290 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 97.34%тай хэрэгжүүлж ажилласан байна. Мөн гоц халдварт шүлхий өвчний вакциныг хавар, намрын давтамжтайгаар 2 удаа хийж гүйцэтгэсэн. Шатахууны зардалд Засаг даргын Тамгын газраас 1,600,000 төгрөг зарцуулсан.			
	17		1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Ламын гэгээний улаан тэмээг үүлдэрээр баталгаажуулахад ОНХС 20.000,000 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж улсын хянан магадлагааны комисс 2 удаа тус сумд ирж ажилласан.	70%	70%	
9	18	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь заалтад Засаг дарга ахмад настыг дэмжих талаар хүлээх үүргийг тусгасан. Уг заалтын хүрээнд ОНХС, иргэдийн хандиваар Ахмадын өргөөг барьж, тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдар, эрүүл	100%	100%	

			шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	мэнддээ анхаарах, төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах болон тэдэнд тулгамддаг эрхийн олон асуудлууд шийдэгдсэн.			
10	19	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ	1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;	тусгай хамгаалалттай газар нутагт газар эзэмшдэг 5 багийн иргэдтэй газар ашиглах гэрээг 100 хувь хийсэн.	100%	100%	
Ерөнхийлөгчийн зарлиг							
11	20	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг	Сумын хэлний бодлогын салбар зөвлөл ард иргэд, төрийн албан хаагчдын дунд “Үндэсний бичгээ өв тэгш суръя” аяныг өрнүүлсэн. “Үндэсний бичгээ өв тэгш суръя” уралдааны үндэсний бичгээр хурдан унших, галигаас хөрвүүлэх, хичээнгүй бичих ганцаарчилсан төрөлд нийт 22 хүн	100%	100%	

			<p>үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.</p>	<p>оролцсон. Төрийн албан хаагчид болон ард иргэдийг баг болгон төрийн байгууллагын 4 баг, ард иргэдийн 2 баг бүрдүүлж үндэсний бичгийн багийн төрөлд 30 хүн оролцсон. Энэ аяны онцлог нь уламжлалт бичлэгтэй үг, гадаад үг, холбоо үг, зүйр үг, галигаас хөрвүүлэх, тийн ялгалаар хувилгах гэсэн 6 төрөлт үгийг урьдчилан бэлтгэж ард иргэд, төрийн байгууллагуудад өгсөн. Өгөгдсөн үгсийн дагуу оролцогчид бэлтгэлээ хангаж сугалаагаар 5 хүнийг баг болгон оролцуулсан. Үүний үр дүнд төрийн албан хаагчид илүү өргөн хүрээтэй хамрагдан үндэсний бичгийн мэдлэгээ дээшлүүлсэн. Мөн үндэсний бичгийг өв тэгш сургахын тулд ганцаарчилсан төрөлд оролцсон бүх хүмүүс унших бичих хөрвүүлэх чадварын бүх төрөлд оролцон нийлбэр дүнгээр үнэлсэн. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 440,000 төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хавсралт : 1 зураг</p>			
12	21	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58</p>	<p>1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох</p>	<p>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын тариалалтаар 10 төрлийн 1750 мод, 3 га газарт заг сухайн үр 1250 шинээр тарьсан. 2023 онд нийт 3000 мод өөрсдийн эзэмшил талбайд тариалсан бөгөөд 150 иргэн буюу 74 өрх айл, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд тарьсан мод тооллого ургалтын</p>	100%	100%	

				хувийг тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж модны ургалтын хувийг тогтоосон. 2021-2023 онд нийт 35600 мод тарьснаас 32800 мод ургасан.Ургалтын хувь 92,1 хувьтай байна.			
	22		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын тариалалтаар 10 төрлийн 1750 мод, 3 га газарт заг сухайн үр 1250 шинээр тарьсан. 2023 онд нийт 3000 мод өөрсдийн эзэмшил талбайд тариалсан бөгөөд 150 иргэн буюу 74 өрх айл, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд тарьсан мод тооллого ургалтын хувийг тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж модны ургалтын хувийг тогтоосон. 2021-2023 онд нийт 35600 мод тарьснаас 32800 мод ургасан.Ургалтын хувь 92,1 хувьтай байна.	100%	100%	
13	23	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	бүх төрийн байгууллагууд Эзэн Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан.	100%	100%	
	24		3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис	Айл өрхүүдэд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залахыг уриалж, судалгаа	70%	70%	

			хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	авахад 80 өрх Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залсан байсан.			
ҮАБЗ-ийн зөвлөмж							
14	25	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын тариалалтаар 10 төрлийн 1750 мод, 3 га газарт заг сухайн үр 1250 шинээр тарьсан. 2023 онд нийт 3000 мод өөрсдийн эзэмшил талбайд тариалсан бөгөөд 150 иргэн буюу 74 өрх айл, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд тарьсан мод тооллого ургалтын хувийг тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж модны ургалтын хувийг тогтоосон. 2021-2023 онд нийт 35600 мод тарьснаас 32800 мод ургасан. Ургалтын хувь 92,1 хувьтай байна.	100%	100%	
ЗГ-ын тогтоол							
15	26	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд	5.1. Шинээр үүсгэх, жигдлэх, орчуулах шаардлагатай нэр томъёо байхгүй. 5.2. Сумын "Хэлний бодлогын салбар зөвлөл" хуралдаж, сумын албан ёсны цахим хуудас болон Хэлний бодлогын салбар зөвлөлийн фэйж хуудсанд оруулж	70%	70%	



		<p>Дугаар 2022_7</p>	<p>захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж</p>	<p>буй мэдээ мэдээллийг крилл монгол бичгээр зэрэгцүүлэн нийтлэх ажлыг туршиж байна. 5.3.2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Төрийн албан хаагчдын нөүтбүүк-д монгол бичгийн кейбоард суулгасан, бичвэрийг үндэсний бичгээр шивж сургах ажлыг туршиж байна. 5.4.Сумын хэлний бодлогын салбар зөвлөл ард иргэд, төрийн албан хаагчдын дунд “Үндэсний бичгээ өв тэгш суръя” аяныг өрнүүлсэн. Аяны хүрээнд монгол бичгийн цахим бичвэр болон унших бичих чадварын сургалтад хамрагдах талаар судалгаа авч нэгтгэсэн. Судалгааны үр дүнд төрийн албан хаагчдын 92% нь цахим бичвэрийн сургалтад хамрагдах сонирхолтой, 95% нь унших бичих чадварын сургалтад хамрагдах сонирхолтой байна. Судалгааны үр дүнд үндэслэн бүх төрийн албан хаагч, ард иргэдэд “Үндэсний бичиг” апплейкешныг сурталчлан таниулж уралдаан зохион байгуулсан.5.5.ИТХ, Засаг даргын Тамгын газар, ЕБС, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг зэрэг төрийн байгууллагууд гаднах хаягаа монгол бичгээр бичсэн. Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг зэрэг байгууллагууд өрөөний тасалгаа болон анги танхимын хаягаа үндэсний бичгээр хаягласан.</p>		
--	--	----------------------	---	--	--	--

			мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
16	27	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279	2.. 2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Тус сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажилд ОНХС-н хөрөнгөөс 105,451,600 мянган төгрөгийг сумын ИТХ-аар батлуулж 2 удаагийн тендер зарласан боловч эхний удаа оролцогч ирээгүй, 2 дахь удаа 2 оролцогч ирсэн боловч шаардлага хангаагүй. Өвс 2000 боодол, ногоон тэжээл 2100 боодол, тэжээлийн будаа 1,2 тн, улаан хивэг 1800 ширхэг уутыг худалдан авахаар төлөвлөсөн байна.Малчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж 181тн өвс, 50,9тн хивэг, 63тн хужир, 17,9тн гар хадланг бэлтгэсэн байна. 2023 оны 11 сарын 14-ний өдөр 1300 боодол өвсийг худалдан авсан.	100%	100%	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
17	28	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар	ХХ.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар	Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр тоон гарын үсгийг олгож эхэлсэн. 2022 онд 704 иргэнд тоон гарын үсэг	100%	100%	

		<p>тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.</p>	<p>олгосон. 2023 онд нийт 1286 иргэнд тоог гарын үсэг олгосон. Үүнээс Иргэний үнэмлэхэнд 908, Гар утсанд 378 тус тус олгосон. Төрийн албан хаагчид тоон гарын үсгээ 100% авсан. Нийт тоон гарын үсэг авах 16-с дээш насны 2539 иргэнээс 2026 иргэн тоон гарын үсэг авсан нь нийт иргэдийн 80 хувьд тоон гарын үсэг олгосон байна. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.</p>			
--	--	--	---	--	--	--	--

18	29	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага,	Сумын хэмжээнд халдварт болон халдвар бус өвчний эрт илрүүлэгт 0-17 насны 1133 хүүхэдээс 1098 хүүхэд үзлэгт хамрагдаж 96.9 хувьтай, 18-с дээш насны үзлэгт хамрагдах 2419 иргэнээс 703 иргэн хамрагдаж 30 хувьтай байна.	70%	70%	
----	----	---	--	--	-----	-----	--

			аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.				
19	30	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Төсөвт бүх байгууллагууд албан бичгийн дундын систем болох ДосХ системд холбогдон ажиллаж байна. Төрийн албаны дотоод сүлжээ буюу ERP албан бичиг солилцооны системийг 100% ашиглаж байна.ЗДТГ нь Албан бичиг солилцооны дундын системийг ашиглан нийт 570 бичиг ирсэн байна. Мөн тус байгууллагаас нийт 211 бичиг явсан байна.	100%	100%	

20	31	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	ХИҮ.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	E-office системийг бүрэн ашиглаж байна. Судалгааг цахим системд байршуулж, нэгтгэх ажлыг Үйлчилгээний оператор Б.Дэлгэрмаад хариуцуулсан. Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг цахимаар авсан.	100%	100%	
21	32	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	ХИХ.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Хүний эрхийн төлөв байдлын тайланг аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан байгууллагуудын камерын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулсан.Сургуулийн орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлийн талаар сурагчидтай ярилцлага өрнүүлж, 6-12 дугаар ангийн сурагчдын ангийн дарга нарт Хүүхдийн эрхийн конвенцийн тухай	100%	100%	

				агуулгаар presentation бэлтгэж сурагчдад танилцуулсан. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь заалтад Засаг дарга ахмад настныг дэмжих талаар хүлээх үүргийг тусгасан. Уг заалтын хүрээнд Ахмадын өргөөг барьж, тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдар, эрүүл мэнддээ анхаарах, төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах болон тэдэнд тулгамдаг эрхийн олон асуудлууд шийдэгдсэн.			
22	33	2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41	XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	2023 оны байдлаар сумын Засаг даргын 5 удаагийн захирамжаар 17 аж ахуйн нэгж байгууллага, 6 төрийн байгууллага, давхардсан тоогоор 215 иргэн 10.1 тонн бүхий хог хаягдлыг түүж цэвэрлэсэн.	100%	100%	
ЗГ-ын албан даалгавар							
23	34	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5	5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	1.1.Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах чиглэлээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 0,4 өргөтгөлийн ажил хийгдэж айл өрхийн цахилгаан болон гудамж орчны гэрэлтүүлэг сайжирсан. 1.2.Сумын төвийн гэр хороолол нь	100%	100%	

		<p>Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт:</p> <p>1.1. Улаанбаатар хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах; 1.2. Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах; 1.3. Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих, төлөвлөгөө, шийдлийг танилцуулах.</p>	<p>нягтаршил бага, гудамжны орц гарч сайтай байдаг учраас түргэн тусламж үзүүлэхэд хүндрэл бэрхшээл төдийлөн гардаггүй давуу талтай. 1.3.2023 оны байдлаар сумын Засаг даргын 5 удаагийн захирамжаар 17 аж ахуйн нэгж байгууллага, 6 төрийн байгууллага, давхардсан тоогоор 215 иргэн 10.1 тонн бүхий хог хаягдлыг түүж цэвэрлэсэн.2023 онд стандартын бус 5 өрх, 2 аж ахуйн нэгжийн нүхэн жорлонг буулгаж шинэчлэх шаардлага хүргүүлэн хэрэгжүүлж ажилласан. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын тариалалтаар 10 төрлийн 1750 мод, 3 га газарт заг сухайн үр 1250 шинээр тарьсан. 2023 онд нийт 3000 мод өөрсдийн эзэмшил талбайд тариалсан бөгөөд 150 иргэн буюу 74 өрх айл, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд тарьсан мод тооллого ургалтын хувийг тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж модны ургалтын хувийг тогтоосон. 2021-2023 онд нийт 35600 мод тарьснаас 32800 мод ургасан.Ургалтын хувь 92,1 хувьтай байна.</p>			
--	--	---	--	--	--	--

.....оОо.....